



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 5 (578)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрийн эрхи байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай*
- *Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх аугдлын тухай*
- *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2009 оны хоёрдугаар сарын 6

№5 (578)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

12.	Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай		74
Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
13.	Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай	Дугаар 04	74
14.	Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай	Дугаар 05	74
15.	Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай	Дугаар 06	74
16.	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 07	77
17.	Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай	Дугаар 08	78
18.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг тогтон зарлах тухай	Дугаар 09	78
19.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай	Дугаар 10	79
20.	Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 11	79
1.	Байнгын хорооны гишүүнээр батлах тухай	Дугаар 12	79
2.	Монгол Улсын Ерөнхий аудиторыг чөлөөлөх тухай	Дугаар 13	79
3.	Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай	Дугаар 14	80
4.	Үндэсний статистикийн хорооны даргыг чөлөөлөх тухай	Дугаар 15	80
5.	Үндэсний статистикийн хорооны даргыг томилох тухай	Дугаар 16	80

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

6.	Лувсандамбын Хуушаанд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 03	81
7.	Долгорын Нямаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 04	81
8.	Пүрэвжавын Пүрэвсүрэнд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 05	81
9.	Дашлхүмбийн Галбаатарт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 06	81
0.	Цэгмидийн Нацагдоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 07	82
1.	Ишдоржийн Цэрэнжамцад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 08	82
2.	Ширсэдийн Цэнд-Аюушид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 09	82
3.	Цэндийн Чимэддоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 10	82
4.	Дамбадаржаагийн Намсрайд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 11	83
5.	Найдангийн Ганхуягт Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 12	83
3.	Жүмлэрэлийн Саруулбуянд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 13	83
7.	Гун-Аажавын Аюурзанад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 14	83
3.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 15	84



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр

Улаанбаатаа хот

МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд дор дурдсан агуулгатай 17^д дугаар зүйл нэмсүгэй:

"17^д дугаар зүйл. Баримт бичиг баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгоход хураах хураамжийн хэмжээ

"Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц"-ийн гишүүн улсад хэрэглэгдэх дотоодын албан ёсны

баримт бичгийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгоход 10000 төгрөгийн хураам: хураана."

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдса өдрөөс нь буюу 2009 оны 01 дүгээр сарын 09-н өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатаа хот

Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 25 дугаар тойрогт 2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр явуулсан ээлжит сонгуулийн дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Цэндийн Мөнх-Оргил, Хишигдэм-

бэрэлийн Тэмүүжин, Дангаасүрэнгийн Энхбат нары бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатаа хот

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томиллох тухай

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8, 21.10, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Норовын Алтансүхийг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилсугай.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь буюу 2009 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатаа хот

Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх

албан тушаалын ангилал, зэрэглэл"-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуу "Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын 1995 оны 42 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭ

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ, УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭНИЙ КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ҮНДСЭНИЙ АЮУЛГУЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО, САНХУУГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, ҮНДСЭНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО, ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ УДИРДАХ, ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

АА-11	Дэс түшмэл			Ахлах түшмэл			Эрэлсж түшмэл			Тэргүүн түшмэл			ангилал		Албан тушаалын ангилал зэрэглэл		
	АА-10	АА-9	АА-8	АА-7	АА-6	АА-5	АА-4	АА-3	АА-2	АА-1	Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд шүүхийн Тамгын газар		Улсын ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба
ахлах зохион байгуулагч	мэргэжилтэн	ахлах мэргэжилтэн	шинэсэн	ахлах шинэсэн	референт	ахлах ахлах референт	тасгийн дарга ахлах зөвлөх	-	хэлтэс, албаны дарга	АА-1	Нарийн бичгийн дарга	Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд шүүхийн Тамгын газар	Улсын ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба
ахлах зохион байгуулагч	мэргэжилтэн	ахлах мэргэжилтэн	шинэсэн	ахлах шинэсэн	референт	ахлах ахлах референт	тасгийн дарга, ахлах зөвлөх	-	хэлтэс, албаны дарга	АА-1	Нарийн бичгийн дарга	Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд шүүхийн Тамгын газар	Улсын ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба
ахлах зохион байгуулагч	мэргэжилтэн	ахлах мэргэжилтэн	шинэсэн	ахлах шинэсэн	референт	ахлах ахлах референт	тасгийн дарга, ахлах зөвлөх	-	хэлтэс, албаны дарга	АА-1	Нарийн бичгийн дарга	Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд шүүхийн Тамгын газар	Улсын ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба
ахлах зохион байгуулагч	мэргэжилтэн	ахлах мэргэжилтэн	шинэсэн	ахлах шинэсэн	референт	ахлах ахлах референт	тасгийн дарга, ахлах зөвлөх	-	хэлтэс, албаны дарга	АА-1	Нарийн бичгийн дарга	Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд шүүхийн Тамгын газар	Улсын ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба
ахлах зохион байгуулагч	мэргэжилтэн	ахлах мэргэжилтэн	шинэсэн	ахлах шинэсэн	референт	ахлах ахлах референт	тасгийн дарга, ахлах зөвлөх	-	хэлтэс, албаны дарга	АА-1	Нарийн бичгийн дарга	Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд шүүхийн Тамгын газар	Улсын ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба
ахлах зохион байгуулагч	мэргэжилтэн	ахлах мэргэжилтэн	шинэсэн	ахлах шинэсэн	референт	ахлах ахлах референт	тасгийн дарга, ахлах зөвлөх	-	хэлтэс, албаны дарга	АА-1	Нарийн бичгийн дарга	Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд шүүхийн Тамгын газар	Улсын ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба
ахлах зохион байгуулагч	мэргэжилтэн	ахлах мэргэжилтэн	шинэсэн	ахлах шинэсэн	референт	ахлах ахлах референт	тасгийн дарга, ахлах зөвлөх	-	хэлтэс, албаны дарга	АА-1	Нарийн бичгийн дарга	Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд шүүхийн Тамгын газар	Улсын ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба
ахлах зохион байгуулагч	мэргэжилтэн	ахлах мэргэжилтэн	шинэсэн	ахлах шинэсэн	референт	ахлах ахлах референт	тасгийн дарга, ахлах зөвлөх	-	хэлтэс, албаны дарга	АА-1	Нарийн бичгийн дарга	Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд шүүхийн Тамгын газар	Улсын ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба

Дэс түшмэл		Ахлах түшмэл			Эрхэлсж түшмэл			Тэргүүн түшмэл		Албан тушаалын ангилал эзэргэлэл	
								АА-8	АА-7	АА-6	АА-5
АА-11	АА-10	АА-9	АА-8	АА-7	АА-6	АА-5	АА-4	АА-3	АА-2	АА-1	Хүний Эрхийн Үндэсний Комиссын ажлын алба
ахлах зөвлөх байгуулагч	морэмжилтөн	ахлах морэмжилтөн	шөнгөж	ахлах шөнгөж	референт	ахлах референт	хэлтэс, тасгийн дарга	-	-	Ажлын албаны дарга	Төрийн албаны зөвлөлийн ажлын алба
ахлах зөвлөх байгуулагч	морэмжилтөн	ахлах морэмжилтэн	шөнгөж	ахлах шөнгөж	референт	ахлах референт	хэлтэс, тасгийн дарга	-	-	Ажлын албаны дарга	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба
ахлах зөвлөх байгуулагч	морэмжилтөн	ахлах морэмжилтөн	шөнгөж	ахлах шөнгөж	референт	ахлах референт	Шуурхай мэдээллийн албаны дарга, эрдэмтэн-багшийн бичгийн дарга	Статистик судалгааны хүрээлэнгийн захирал	-	Ажлын албаны дарга	Сонгуулийн ерөнхий хорооны ажлын алба
ахлах зөвлөх байгуулагч	морэмжилтөн	ахлах морэмжилтөн	шөнгөж	ахлах шөнгөж	референт	ахлах референт	талстийн дарга	-	-	Ажлын албаны дарга	Үндэсний статистикийн хороо
ахлах зөвлөх байгуулагч	морэмжилтөн	ахлах морэмжилтөн	шөнгөж	ахлах шөнгөж	статистич	ахлах статистич	газарын орлогч дарга, хэлтэсний дарга	газарын дарга	-	Тамган газрын дарга	Санахуугийн зохицуулах хорооны ажлын алба
ахлах зөвлөх байгуулагч	морэмжилтэн	ахлах морэмжилтэн	шөнгөж	ахлах шөнгөж	референт	ахлах референт	газарын орлогч дарга, хэлтэс албаны дарга	газарын дарга	-	Ажлын албаны дарга	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба
ахлах зөвлөх байгуулагч	морэмжилтөн	ахлах морэмжилтэн	шөнгөж	ахлах шөнгөж	референт	ахлах референт	Шүүхийн сахилгын хорооны эвлэл, шалгалч, ахлах шөнгөж	Шүүхийн сахилгын хорооны эвлэл, шалгалч, ахлах шөнгөж	-	-	

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр
 ирэн 16-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
 хот

Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2008 оны төсвийн йцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн ялан батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

2/“Монгол Улсын 2010 оны төсвийн рээний мэдэгдэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

3/Монгол Улсын Их Хурлын тухай болон энгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны гийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

4/Хийн хангамжийн тухай хуулийн төсөл болон түүнтэй холбогдох бусад хуулийн төслүүд;

5/Хадгаламж, зээлийн хоршооны тухай, идгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг дагаж ирдэх журмын тухай хуулийн төсөл, “Хууль рэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их рлын тогтоолын төсөл, Хоршооны тухай хуульд мэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн хицуулах хорооны эрх зүйн байдлын тухай ульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

6/Мэргэжлийн сургалт, техникийн повсролын тухай хуулийн төсөл /шинэчилсэн йруулга/;

7/Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай улийн төсөл;

8/Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай улийн төсөл /шинэчилсэн найруулга/;

9/Бичил уурхайгаас ашигт малтмал борлох тухай; Ашигт малтмал гар үйлдвэрлэлийн аар олборлох тухай хуулийн төслүүд;

10/Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

11/Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

12/Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

13/Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл / Засгийн газраас 2007.10.16-нд өргөн мэдүүлсэн/;

14/“Эртний нийслэл Хархорумыг жишиг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

15/“Эрдэс баялгийн салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

16/“Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээний дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

17/“Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

18/Эх орны хишиг сангийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд;

19/Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

20/Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

21/Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээг тогтоох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

22/Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2007.09.24-нд өргөн мэдүүлсэн/;

23/Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол" болон "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг тогтоох сүлжээ"-г шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

24/Төрийн албаны гавъяат ажилтан цол бий болгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

25/бусад.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их

Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг 2009 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухайн үед нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3. Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр энэ тогтоол дурдаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас 2009 оны 3 дугаар сарын 20-ны дотор өргөн мэдүүлбэл энэ оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлыг дараалалд оруулахыг Улсын Их Хурлын дарга зөвшөөрсүгэй.

4. Улсын Их Хурлын 2009 оны хаврыг ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэ хангахыг Засгийн газар /С.Баяр/, Байнгын хороодыг дарга, Улсын Их Хурал дахь намын бүлгийн ахлагч нар болон Тамгын газар /Ц.Шараадорж/-т тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 08

Улаанбаат хот

Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралын улмаас учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, улсын төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор 300 хүртэлх тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаж, арилжаалахыг Засгийн газар /С.Баяр/-т зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны арилжааны орлогын эх үүсвэрийг улсын төсвийн улирлын чанартай

орлогын дутагдлыг нөхөхөөс бусад зориулалтаа зарцуулах тохиолдолд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороотой зөвшилцөн шийдвэрлэж байхыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

3. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс буюу 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 09

Улаанбаат хот

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 9 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 2009 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн анх шатны сонгуулийн санал хураалтыг 2009 оны дугаар сарын 24-ний өдөр явуулахаар тогтоосугай.

3. Энэ тогтоолыг 2009 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭ**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:
1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 4 000 000 000 /дөрвөн тэрбум/ төгрөгөөр огтоосугай.

2. Энэхүү зардлыг улсын төсвөөс гаргахыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2009 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Улсын Их Хурал дахь МАХН-ын үлгийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Дэндэвийн эрбишдагвыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн

байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Хууль зүйн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

2. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Байнгын хорооны гишүүнээр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Иргил, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарыг Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн

Дангаасүрэнгийн Энхбатыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхий аудиторыг чөлөөлөх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын үйлганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Лхамсүрэнгийн Жавзмааг Монгол Улсын

Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатаг хот

Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Чойжамцын Раднааг Монгол Улсын Ерөнхий аудитороор томилсугай.
2. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатаг хот

Үндэсний статистикийн хорооны даргыг чөлөөлөх тухай

Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 6 дахь хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндэсний статистикийн хорооны даргын үүрэг ажлаас чөлөөлсүгэй.
2. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1. Бүрэн эрхийнх нь хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Пандийн Бямбацэрэнг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатаг хот

Үндэсний статистикийн хорооны даргыг томилох тухай

Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сономцэрэнгийн Мэндсайханыг Үндэсний статистикийн хорооны даргаар томилсугай.
2. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

09 оны 01 дүгээр
рын 08-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Лувсандамбын Хуушаанд Монгол Улсын
соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Төрийн захиргааны төв болон төрийн бус
йгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж,
энгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааг
рөгжүүлэх, гадаадтай соёлоор харилцах ажлыг
ирдан зохион байгуулж, улс түмний энх тайван
йрамдлыг бэхжүүлэх, Монголын утга зохиолд
/лэг, найраглал, үргэлжилсэн үг болон орчуулгын
тээлүүдээрээ оруулсан хувь нэмрийг нь үнэлж

Монголын энх тайван, найрамдлын
байгууллагуудын холбооны ахмад зүтгэлтэн,
зохиолч, орчуулагч Лувсандамбын Хуушаанд
Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол
хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

09 оны 01 дүгээр
рын 08-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Долгорын Нямаад Монгол Улсын соёлын
гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Утга зохиол, соёл урлаг, хэвлэл
идээллийн байгууллагад олон жил үр бүтээлтэй
ахлаж богино шүлгийн болон сэтгүүл зүйн зарим
рлөөр шилдэг шүлэг, бүтээлүүд туурвиж,
энголын утга зохиолд шүлэг яруу найргийн
өрмөц урсгалыг хөгжүүлэхэд оруулсан хувь

нэмрийг нь үнэлж зохиолч Долгорын Нямаад
Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол
хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

09 оны 01 дүгээр
рын 08-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Пүрэвжавын Пүрэвсүрэнд Монгол Улсын
соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монголын утга зохиол, хэвлэл мэдээллийн
йгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй
ахлаж, уншигч олны талархал хүлээсэн «Танил
рвоо», «Их тээлийн даваа», «Үдийн нар өндөр»
рэг яруу найраг, тууж, өгүүллэгийн ном,
тээлүүд туурвиж, зохиолч, сэтгүүлчдийн
лгамж үеийг сургаж бэлтгэн хэвлэл, утга

зохиолын салбарт оруулсан хувь нэмрийг нь үнэлж
зохиолч, яруу найрагч Пүрэвжавын Пүрэвсүрэнд
Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол
хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

09 оны 01 дүгээр
рын 08-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

Дашлхүмбийн Галбаатарт Монгол Улсын
гавъяат багш цол хүртээх тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, утга
хиолын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж,
ан зохиолын онол, түүхийн тулгамдсан
уудлаар судалгааны нэгэн сэдэвт бүтээл, уран
йхны шүүмжлэл судлал, толь бичиг, дэлхийн
ан зохиолоор эрдэмтэд, оюутнуудад зориулсан
м, сурах бичиг, гарын авлага туурвиж,
далгааны шинэ чиглэлийг бий болгох, утга
хиолын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх,

Монголын уран зохиолыг судалж сурталчлах,
хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж
МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн багш,
доктор, профессор Дашлхүмбийн Галбаатарт
Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Цэгмидийн Нацагдоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээллийн байгууллагад олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж, тайз, дэлгэц, тууж, өгүүллэгийн бүтээлүүд туурвиж, "Чингис хааны зарлигийн товчоон", "Чингис хааны сургаалийн товчоон" хэмээх төрт ёс, иргэний зан суртахууны захиас, гэрээс, билиг сургаал бүхий 2 боть эмхтгэл бүтээлийг нийтийн хүртээл болгож, Монгол

үндэстний эх оронч үзэл ухамсрыг төлөвшүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж зохиолч, сэтгүүлч Цэгмидийн Нацагдоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Ишдоржийн Цэрэнжамцад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл урлаг, утга зохиол, хэвлэл мэдээллийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, "Хошин өргөө", "Хүрэл инээмсэглэл", "Уянгын хошин холбоо тууж" зэрэг яруу найраг, хүүрнэл болон хошин шог зохиолын олон арван бүтээл туурвиж, гадаадын зохиолчдын шилдэг бүтээлийг эх хэлнээ орчуулан Монголын утга

зохиолын үе, жилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж зохиолч, орчуулагч Ишдоржийн Цэрэнжамцад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Ширсэдийн Цэнд-Аюушид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Урлаг утга зохиол, нийгэм соёл, шинжлэх ухааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж өгүүллэг, тууж, уран зохиол судлалын олон арван ном бүтээл туурвиж, утга зохиолын залуу хойч үеийг сургаж бэлтгэх, соёл, урлаг, утга зохиолын салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж зохиолч, утга зохиол

судлаач, доктор, профессор Ширсэдийн Цэнд-Аюушид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Цэндийн Чимэддоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээлэл, утга зохиолын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж "Морь буусан шагай", "Долоон бурхан", "Улаан тэргэл өдөр" зэрэг яруу найргийн бүтээл туурвин, "Арслантай авдар", "Малчин заяа", "Наран доорхи наадам" зэрэг олны хүртээл болсон олон арван дууны шүлэг зохиож, Монголын радиогийн "Малчин" нэвтрүүлгийн редактороор 30 шахам жил тасралтгүй ажиллан,

Монгол үндэстний соёл, утга зохиол, урлагийн хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж МҮОНФ-ийн "Малчин" нэвтрүүлгийн редактор, сэтгүүлч, яруу найрагч Цэндийн Чимэддоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

109 оны 01 дүгээр
арын 08-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

**Дамбадаржаагийн Намсрайд Монгол Улсын
соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Утга зохиол, хэвлэл мэдээллийн
ийгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж
андирсын хотын Хандармаа, "Тооройн төгөл",
"үүриймаа" зэрэг тууж, "Жамухын өчил",
"эгцэрийн шар тал" зэрэг өгүүллэг, хүүрнэл
хнол, жүжиг, киноны төрлөөр шилдэг бүтээлүүд
урвиж, Монголын утга зохиолыг хөгжүүлэхэд

оруулсан хувь нэмрийг нь үнэлж зохиолч
Дамбадаржаагийн Намсрайд Монгол Улсын соёлын
гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

109 оны 01 дүгээр
арын 08-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

**Найдангийн Ганхуягт Монгол Улсын
урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Соёл урлаг, утга зохиол, боловсролын
салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж 10 гаруй
жиг, киноны зохиол бичиж найруулан, театр
длал, шүүмжийн шилдэг ном бүтээлүүд туурвиж,
нл урлагийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх
лон Монголын тайз дэлгэцийн урлагт оруулсан

хувь нэмрийг нь үнэлж СУИС-ийн тэнхимийн
эрхлэгч Найдангийн Ганхуягт Монгол Улсын
урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

109 оны 01 дүгээр
арын 08-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

**Жүмпэрэлийн Саруулбуянд Монгол Улсын
соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Утга зохиол, хэвлэл мэдээллийн
ийгууллагад үр бүтээлтэй ажиллаж, дууны яруу
йраг, баримтат уран зохиол, морин соёл
длалын чиглэлээр туурвисан олон бүтээлээрээ
онголын утга зохиолын хөгжилд оруулсан хувь
нмрийг нь үнэлж Үндэсний түүхийн музейн

захирал, зохиолч, доктор Жүмпэрэлийн
Саруулбуянд Монгол Улсын соёлын гавъяат
зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

09 оны 01 дүгээр
арын 08-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

**Гун-Аажавын Аюурзанад Монгол Улсын
соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Монголын утга зохиолын салбарт шинэлэг
тгэлгээ, өвөрмөц өнгө аяс, өөрийн арга барил
хий яруу найраг, үргэлжилсэн үгийн чансаатай
тээлүүд туурвиж, хүн төрөлхтний оюун
тгэлгээний өв, дэлхийн шилдэг зохиолуудаас
чуулан хөрвүүлж, уншигч олон түмний уран
йхны болон гүн ухааны боловсрол сэтгэлгээг

хөгжүүлэх, нийгмийг гэгээрүүлэх үйлсад оруулж
байгаа хувь нэмрийг нь үнэлж зохиолч, яруу
найрагч, орчуулагч Гун-Аажавын Аюурзанад Монгол
Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хо

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улсад зохиолчдын байгууллага олон жил үр бүтээлтэй ажиллаж гарамгай аргасан дор дурдсан хүмүүсийг одон, медаль, соёл урлаг, хэвлэл мэдээллийн салбарт шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- | | |
|---|--|
| 1. Санжжавын Даваахүү - Монголын үндэсний чөлөөт зохиолчдын холбооны ажилтан, зохиолч | 5. Данзангийн Нямаа - МҮОНРТ-ийн соёл, уран сайхны редакцийн ерөнхий редактор, яруу найрагч |
| 2. Чойжилын Дамдиндорж - "Дөл импекс" ХХК-ийн захирал, яруу найрагч | 6. Барын Цэдэв - Шүүмжлэгч, судлаач |
| 3. Дамдины Жамъян - Нямгаваа фильм продакшны продюсер, зохиолч | 7. Авидын Шартолгой - Нийслэлийн Чөлөөтэй дүүргийн 4 дүгээр хорооны өндөр нийслэлийн зохиолчдын эвлэлийн шагналт зохиолч |
| 4. Чимэддоржийн Нацагдорж - Зохиолч | 8. Заяатын Ядмаа - Нийслэлийн Баянгол дүүргийн 8 дугаар хорооны иргэн, яруу найрагч |

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- | | |
|--|---|
| 1. Цогдоржийн Бавуудорж - МҮОНРТ-ийн Олон нийтийн радиод нийгмийн нэвтрүүлгийн албаны ерөнхий редактор, яруу найрагч | 11. Ламжавын Мягмарсүрэн - Яруу найрагч |
| 2. Жамсрангийн Баяржаргал - Монголын зохиолчдын эвлэлийн "Утга зохиол, урлаг" сонины эрхлэгч | 12. Бямбажавын Нарантуяа - Орчуулагч |
| 3. Цэнд-Аюушийн Буянзаяа - Хэвлэлийн "Чөлөөт Монгол" компанийн захирал, яруу найрагч | 13. Лувсанвандангийн Нарангэ - Орчуулагч, яруу найрагч |
| 4. Баатарын Галсансүх - "Ноцтой мэдээ" сонины эрхлэгч, яруу найрагч | 14. Лувсандоржийн Өлзийтөгс - Орчуулагч, яруу найрагч |
| 5. Даваасүрэнгийн Ган-Очир - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн, яруу найрагч | 15. Санжийн Пүрэв - Монголын эмнэлгийн холбооны зөвлөх, зохиолч |
| 6. Баярхүүгийн Ичинхорлоо - "Монголын нууц товчоо" дээд сургуулийн багш, яруу найрагч | 16. Балжиннямын Пүрэвдорж - Хөгжлийн бүжгийн коллежийн багш, зохиолч |
| 7. Жамбалын Зана - Зохиолч, яруу найрагч | 17. Айлтгүйн Төмөр-Очир - Сүхбаатар аймгийн ИТХ-ын төлөөлөгч, яруу найрагч |
| 8. Шагдарын Лхамноржмаа - "Нигүүсэл" сонины хариуцлагатай нэрийн бичгийн дарга, яруу найрагч | 18. Цэрэнтулгын Түмэнбаяр - Монголын зохиолчдын эвлэлийн удирдах зөвлөлийн гишүүн |
| 9. Гомпилдоогийн Мөнхцэцэг - "Нью Майнд" хэвлэлийн үйлдвэрийн захирал, яруу найрагч | 19. Цоодолын Хулан - "Ардын төрсөн" сонины ерөнхий эрхлэгч, яруу найрагч |
| 10. Лханаагийн Мөнхтөр - МҮОНРТ-ийн Олон нийтийн радиогийн редактор, сэтгүүлч | 20. Даваасүрэнгийн Чинзориг - Урлагийн их сургуулийн багш, яруу найрагч |
| | 21. Даваадоржийн Энхболдбаяр - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажилтан, яруу найрагч |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | |
|--|--|
| 1. Баяртогтохын Батрэгээдмаа - Яруу найрагч, сурвалжлагч | |
| 2. Чанцалын Үл-Олдох - "Зууны мэдээ" сонины сэтгүүлч | |

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газар
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 262420
Индекс 14003

☎ 32941
Хэвлэлийн хуудас 1.5